



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/88/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхтуул
Утас: 261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэст фортуна аудит ХХК
Захирал Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
Цахим хаяг: fortune2009audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа	13
8.2 Төлбөрийн акт.....	13
8.3 Албан шаардлага	14
8.4 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УДШ	Улсын Дээд Шүүх
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЯ	Эрчим Хүчний Яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/583

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/15 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 3,845.2 сая төгрөгөөр, улсын төсвийн татаасыг 1,377.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,833.3 сая төгрөгөөр, алдагдлыг 611.1 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 5,254.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,848.9 сая төгрөгийн зардал гарган, 594.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 93.7 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,614,829.29	75,297,543.92
1.1.2	Дансны авлага	693,976,015.04	659,259,592.49
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	325,362,159.97	292,790,563.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,023,953,004.30	1,027,347,699.80
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,287,915,279.69	8,907,310,898.95
1.2.2	Биет бус хөрөнгө	1,844,589,181.89	1,838,520,424.35
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,132,504,461.58	10,745,831,323.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,156,457,465.88	11,773,179,023.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,179,975,719.91	1,069,797,159.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	126,920,460.45	177,527,130.88
2.1.1.4	НДШ - ийн өглөг	89,459,268.44	156,541,407.49
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		40,323,663.24
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	13,907,476.75	8,429,710.14
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,410,262,925.55	1,452,619,070.75
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,410,262,925.55	1,452,619,070.75
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	6,373,866,456.47	8,534,873,748.12
2.3.2	- хувийн		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,727,654,260.64	2,727,654,260.64
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,981,441,290.92	1,988,815,812.91
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,336,767,467.70)	(2,930,783,869.32)
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,746,194,540.33	10,320,559,952.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,156,457,465.88	11,773,179,023.10

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,720,743,260.40	3,832,453,211.26
2	Борлуулалтын өртөг	5,492,062,174.07	5,672,993,146.36
3	Нийт ашиг(алдагдал)	(1,771,318,913.67)	(1,840,539,935.10)
4	Түрээсийн орлого	2,749,090.92	2,288,181.83
5	Хүүний орлого	9,918,869.55	75,867.32
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	324,183,120.68	168,199,857.61
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	128,220,007.63	125,658,015.39
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	1,058,573,150.18	1,201,617,642.11
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(504,114,689.97)	(594,016,401.62)
19	Орлогын татварын зардал		-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(504,114,689.97)	(594,016,401.62)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(504,114,689.97)	(594,016,401.62)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,373,866,456.47	2,727,654,260.64	1,820,434,000.00	(1,877,471,427.96)	9,044,483,289.15
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				44,818,650.23	44,818,650.23
3	Залруулсан үлдэгдэл	6,373,866,456.47	2,727,654,260.64	1,820,434,000.00	(1,832,652,777.73)	9,089,301,939.38
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(504,114,689.97)	(504,114,689.97)
6	Өмчид гарсан өөрчлөлт			2,161,007,290.92		2,161,007,290.92
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,373,866,456.47	2,727,654,260.64	3,981,441,290.92	(2,336,767,467.70)	10,746,194,540.33
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын					-

Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	6,373,866,456.47	2,727,654,260.64	3,981,441,290.92	(2,336,767,467.70)	10,746,194,540.33
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(594,016,401.62)	(594,016,401.62)
14	Өмчид гарсан өөрчлөлт	2,161,007,291.65		(1,992,625,478.01)		168,381,813.64
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,534,873,748.12	2,727,654,260.64	1,988,815,812.91	(2,930,783,869.32)	10,320,559,952.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,428,762,024.05	5,806,842,605.68
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,989,765,162.45	4,388,237,915.68
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	12,980.00	
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	25,703,374.00	20,714,725.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	1,238,000,000.00	1,377,000,000.00
	Бусад мөнгөн орлого	175,280,507.60	20,889,965.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,401,445,385.03	5,650,836,185.87
	Ажиллагчдад төлсөн	1,535,970,127.42	1,566,834,917.13
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	465,000,000.00	406,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	142,521,603.00	234,597,162.00
	Ашиглалтын зардалд төлсөн	559,435,224.08	733,451,627.39
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,141,986,024.58	2,105,223,495.45
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	309,024,358.01	362,115,823.80
	Даатгалын төлбөрт төлсөн	1,187,900.00	49,202,320.00
	Бусад мөнгөн зарлага	246,320,147.94	193,410,840.10
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	27,316,639.02	156,006,419.81
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,918,869.55	75,867.32
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	9,918,869.55	75,867.32
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	128,385,500.00	85,399,572.50
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	128,385,500.00	85,399,572.50
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(118,466,630.45)	(85,323,705.18)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-

Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(91,149,991.43)	70,682,714.63
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	95,764,820.72	4,614,829.29
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,614,829.29	75,297,543.92

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дулаан үйлдвэрлэлт	мян.Гкал	94.9	97.3	97.4	0.1	100.1
2	Нийт орлого	мян.төг	4,057,594.4	3,845,185.9	4,003,017.1	157,831.2	104.1
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	3,720,629.2	3,745,715.6	3,832,453.2	86,737.6	102.3
	Бусад орлого /Маягт, тендер техникийн нөхцөл, үнсний, алданги торгуулийн, угаалгын, засвар үйлчилгээний орлогууд/	мян.төг	336,965.2	99,470.3	170,563.9	71,093.6	171.5
3	Нийт зардал	мян.төг	5,687,163.5	5,833,312.7	5,848,851.7	15,539.1	100.3
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	128,220.0	133,367.8	125,658.0	(7,709.8)	94.2
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(1,629,569.1)	(1,988,126.7)	(1,845,834.6)	142,292.1	92.8
5	Улсын төсвийн татаас	мян.төг	1,125,454.5	1,377,000.0	1,251,818.2	(125,181.8)	90.9
6	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	(504,114.6)	(611,126.7)	(594,016.4)	17,110.3	97.2
7	<u>Төсвийн төлбөрт нийт дүн</u>	мян.төг	1,213,719.2	1,078,635.8	1,214,108.5	135,472.7	112.6
	а/ Орлогын татварт	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
	б/ НӨТ	мян.төг	522,777.2	547,238.9	529,181.9	(18,057.0)	96.7
	в/ НДШ	мян.төг	515,522.4	335,239.8	522,082.1	186,842.3	155.7
	г/ ХАОАТатвар	мян.төг	161,770.1	182,759.7	148,682.2	(34,077.5)	81.4
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	9,870.1	9,870.1	9,870.1	0.0	100.0
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	848.0	448.4	196.0	(252.4)	43.7
	ж/ Бусад татвар /Газрын төлбөрт/	мян.төг	1,250.2	1,401.6	0.0	(1,401.6)	0.0
з/ Агаарын бохирдлын төлбөрийн татвар	мян.төг	1,681.2	1,677.3	4,096.2	2,418.9	244.2	
8	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	122.0	122.0	122.0	0.0	100.0
10	Нийт цалингийн сан	мян.төг	1,928,702.9	1,963,477.6	1,893,327.9	(70,149.7)	96.4
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,317.4	1,341.2	1,293.3	(47.9)	96.4
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төг	59,243.3	58,893.0	59,534.4	641.4	101.1
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.5	1.6	1.5	(0.1)	95.4
14	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	128,003.0	146,765.8	131,208.3	(15,557.5)	89.4
15	Нийт авлага	мян.төг	693,976.0	350,000.0	659,259.6	309,259.6	188.4
	Үүнээс: Найдваргүй	мян.төг			0.0	0.0	
16	Нийт өглөг	мян.төг	1,410,262.9	1,048,000.0	1,452,619.1	404,619.1	138.6
	Үүнээс: Богино хугацаат	мян.төг	1,410,262.9	1,048,000.0	1,452,619.1	404,619.1	138.6

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өглөг, авлагыг барагдуулах, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, журмыг мөрдөх, үндсэн болон нэмэгдэл цалин хөлсийг зөв тооцож олгох, ХХОАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 28-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Бэст фортуна аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Б.Оюундэлгэр, аудиторын туслах Н.Чимгээ, Д.Болормаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ж.Оюунцэцэг хэрэгжүүлсэн.

Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Бэст фортуна аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан зарим бүртгэлүүдийг тусгаагүй байна.

Налайхын Дулааны станц ТӨХК нь гүйцэтгэх захирлын 2018 оны А/14 дүгээр тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баталсан байна. Тайлант онд дотоод аудитын ажилтан 5 ажил гүйцэтгэхээр төлөвлөж, төлөвлөсөн ажлаа 100.0 хувь гүйцэтгэн, дотоод хяналт шалгалт явуулах ажлын удирдамжийн дагуу ажлын тайлан, танилцуулга бэлтгэж, зөвлөмж гарган, биелэлтийг тооцон ажилласан байна. Тайлант онд Эрчим Хүчний Яамны дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, Зөрчилгүй үнэлгээ өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 5,620.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 56.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Налайхын дулааны станц ТӨХК зорилгоо “Хэрэглэгчээ дээдлэн, дэвшилтэд технологид түшиглэсэн дулааны эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэрлэл эрхэлж, ажил, үйлчилгээ үзүүлэх гэж тусгажээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Налайхын дулааны станц ТӨХК нь БНМАУ-ын Сайд Нарын Зөвлөлийн 1976 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолоор “Налайх тосгоны дулааны станц” нэртэйгээр анх байгуулагдсан ба Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор бие даасан төрийн өмчит хувьцаат компани болсон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх 76.1.8-д “компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох”; 77 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох 77.1-д “Энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно” заалттай нийцэж байна.

Налайхын дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.5 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д

“...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно, цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд компанийн техникийн бодлогын баримт бичиг, хэмнэлтийн бодлогын баримт бичиг, хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулах талаар өөрчлөлт хийгдээгүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Налайхын дулааны станц ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,164.8	75,297.5	71,162.7
БХХО			
Авлага	693,976.0	659,259.6	(34,716.4)
Урьдчилгаа			
Бараа материал	325,362.2	292,790.6	(32,571.6)
Үндсэн хөрөнгө	9,287,915.3	8,907,310.9	(380,604.4)
Биет бус хөрөнгө	1,844,589.2	1,838,520.4	(6,068.8)
Нийт хөрөнгийн дүн	12,156,457.5	11,773,179.0	(383,278.5)
Өр төлбөрийн дүн	1,410,262.9	1,452,619.1	42,356.2
Богино хугацаат өглөг	1,410,262.9	1,452,619.1	42,356.2
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	10,746,194.6	10,320,559.9	(425,634.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,156,457.5	11,773,179.0	(383,278.5)

Касс дахь бэлэн мөнгө 0.8 сая, банканд дахь харилцах дансанд 74.5 сая төгрөг байна.

Тайлант онд өмнөх оноос аж ахуйн нэгжээс авах авлага 117.9 сая, айл өрхийн авлага 340.5 сая төгрөгөөр буурсан боловч, төсвийн байгууллагаас авах авлага 209.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын дүнд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 566.9 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 92.4 сая төгрөгийн авлага байгаагийн дотор Улсын дээд шүүхийн шатанд хянагдаж байгаа 74.5 сая төгрөгийн, найдваргүй болох эрсдэлтэй 17.9 сая төгрөгийн авлага байна. Тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй, шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон 5 харилцагчийн 2.1 сая төгрөгийн авлагыг данснаас хассан байна.

Тайлант онд 1,582.7 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийснээс нүүрс 1,361.9 сая төгрөг буюу 86.0 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 96.4 сая, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засварын капиталжуулалт 75.9 сая, иргэдээс үнэ төлбөргүй шилжүүлэн авсан шугам сүлжээний тоног төхөөрөмж 92.5 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгджээ.

Биет бус хөрөнгө худалдан авсан хүний нөөцийн программ 3.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлан оны 9.4 сая төгрөгийн хорогдуулгаар хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд нүүрс болон тээвэрлэлтийн өглөг 511.3 сая, татвар, НДШ-ийн өглөг 334.1 сая, урьдчилж орсон орлого 40.3 сая, бусад өглөг 566.9 сая нийт 1,452.6 сая төгрөгийн өр байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын данснүүдэд хуримтлуулан бүртгэх ба аккруэл суурьт бүртгэлийн хувьд ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт дулаан үйлдвэрлэхтэй холбогдон гарсан нүүрс, нүүрсний тээврийн зардал, шатах, тослох материал, ашиглалтын зардал, сэлбэг хэрэгсэл, үйлдвэрийн ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, түүхий эд материал, үндсэн хөрөнгийн элэгдэл, урсгал засвар, хөдөлмөр хамгаалал болон бусад зардлуудыг цех, тасгаар ангилан хамруулсан байна.

4.4. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Налайхын дулааны станц ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/15 дугаар тушаалаар Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,845.2 сая төгрөгөөр, улсын төсвийн татаасыг 1,377.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,833.3 сая төгрөгөөр, 611.1 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалт, их засвар, техникийн зохион байгуулалтын арга хэмжээнд 146.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 5,254.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,848,9 сая төгрөгийн зардал гарган, 594.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 5,254.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 32.6 сая төгрөг буюу 4.1 хувиар давсан нь шинэ хэрэглэгч нэмэгдсэн, хэрэглэгчийн төрөл өөрчлөгдсөн нь нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 5,848.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 15.5 сая төгрөг буюу 0.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаа нь шатахууны үнэ, нүүрсний тээврийн зардлын өсөлтөөс шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 16 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 131.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 594.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 17.1 сая төгрөгөөр буурсан нь өөрийн орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40.0 хувь буюу 2.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Налайхын Дулааны станц ТӨХК нь тайлант онд нийт 10,254.5 сая төгрөгийн 341 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулсан байна

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахад 1.9 сая төгрөг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахад зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 171.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 171.5 сая төгрөгийг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчлийг арилгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 64.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 12.6 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснөөс акт, албан шаардлага 100.0 хувийн биелэлттэй, зөвлөмжийн хэрэгжилт 87.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	649.0	1	649.0	-	-	100.0
Албан шаардлага	1	64,165.8	1	64,165.8	-	-	100.0
Зөвлөмж	7	12,564.2	6	12,404.4	1	159.8	85.7
Нийт дүн	9	77,379.0	8	77,219.2	1	159.8	95.2

Өмнөх оны аудитаар өгсөн Тэлмэн констракшн ХХК-аас авах авлагыг барагдуулах албан шаардлагын дагуу шүүхийн байгууллагад хандаж, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны болон Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр гарсан ба Улсын Дээд шүүхийн хяналтын шатанд хянагдаж байгаа бөгөөд асуудлыг яаралтай шийдүүлэх талаар удаа дараа хүсэлт гаргасан боловч, хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчлөх боломжгүй гэсэн хариуг УДШ-с ирүүлсэн тул хэрэгжих шатандаа байна.

Нүүрсний үлдэгдэлд хийсэн маркшейдерийн хэмжилтийн үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон дулааны тарифаас шалтгаалан борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 1.5 төгрөг болсон, олон жил алдагдалтай ажиллаж байгаагаас өр төлбөр ихээр хуримтлагдан мөнгөн хөрөнгийн дутагдалд орсноос үйл ажиллагаа хэвийн явуулахад хүндрэл үүсэж байгааг харьяалах дээд шатны захирагч анхаарч, бодлогын чанартай арга хэмжээ авах шаардлагатай байна.

Тэлмэн констракшн ХХК-аас авах авлагыг шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн шийдвэр, түүний биелэлтийг дараагийн аудитаар авч үзнэ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 95.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 70.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 19.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 5.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 26.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 45.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Зөрчилгүй" санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 70.9 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын 68.9 сая гүйлгээг бууруулсан бичилт хийсэн;
- Зардал бууруулах 2.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн.

8.2 Төлбөрийн акт

Ажиллагсад ажил хавсран гүйцэтгүүлсний болон илүү цагийн мөнгийг буруу тооцоолж, 0.4 сая төгрөг илүү олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Захирал дараах эрх, үүрэгтэй"... 20.1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "аж ахуйн нэгж байгууллага, нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"...заалт, 5.1.4-т "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

1. Таваас дээш жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй 8 байгууллага, иргэнтэй холбоотой 17.9 сая төгрөгийн авлагыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, найдваргүй авлагын нөөц байгуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах"; 20.2.6-т "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Тайлант онд нүүрсний үлдэгдэлд маркшейдерийн хэмжилт хийлгэсэн боловч 39.2 тонны зөрүү үүссэнийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаарх ААНОАТ-ын 2.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл, татварын цахим систем дэх тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах"; 20.2.6-т "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагатай улирал бүр тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх

2. **Орлогын данстай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

Төрийн өмчийн түрээсийн орлогыг нийт дүнгээр хүлээн зөвшөөрч, ТӨБЗГ-т төвлөрүүлсэн хэмжээгээр 1.9 сая төгрөгийн орлого бууруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Захирал дараах эрх, үүрэгтэй"... , 20.1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар

зүйлийн 5.1-т "аж ахуйн нэгж байгууллага, нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"...; 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн түрээсийн орлогыг тухайн байгууллагад ногдох хэмжээгээр орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх, ТӨБЗГ-т төвлөрүүлэх хэмжээгээр өглөг үүсгэн төлөгдсөн үед өглөгийг хаах дансны бичилт хийж байх

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

3.1 Илрүүлэлт:

Байгууллагын НБББББ-т орлого, зардал, ашиглалтад байгаа хангамжийн материалын данстай холбоотой байгууллагын онцлогт тохируулсан бүртгэлийн талаар заалтыг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"; 20.2.2-т "аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, тайлант хугацааны ажил гүйлгээний "ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Буцаасан орлого, ашиглалтад байгаа хангамжийн материал, найдваргүй авлагын нөөц байгуулах зэрэг онцлогуудыг тусгасан бүртгэлийг боловсруулж НБББББ-т нэмэлт өөрчлөлтийг оруулах

4. Зардлын данстай холбоотой

4.1 Илрүүлэлт:

Ажиллагсдад олговол зохих цалинг буруу тооцож 0.4 сая төгрөгийг дутуу олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Захирал дараах эрх, үүрэгтэй"...; 20.1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "аж ахуйн нэгж байгууллага, нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"...; гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Цалин хөлсний тооцооллыг зөв хийх, тооцоололд хяналт хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1			5-аас дээш жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй 8 байгууллага, иргэнтэй холбоотой авлагыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, найдваргүй авлагын нөөц байгуулаагүй	Найдваргүй авлагын нөөц байгуулах, олон жил болсон авлагын асуудлыг ТУЗ-оор хэлэлцүүлж шийдвэрлүүлэх	1	17,856.5						1	17,856.5			
2			Балансаарх ААНОАТ-ын өглөгийн үлдэгдэл, татварын цахим системээрх үлдэгдлээс зөрүүтэй	Татварын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг тохируулах	1	2,819.1									1 2,819.1	
3			Төрийн өмчийн түрээсийн орлогыг нийт дүнгээр хүлээн зөвшөөрч, ТӨБЗГазарт төвлөрүүлсэн хэмжээгээр орлого бууруулсан	Орлогыг өөрт ногдох хэмжээгээр хүлээн зөвшөөрч, төвлөрүүлэх хэмжээгээр өглөг үүсгэж байх	1	1,980.0									1 1,980.0	
4			Нүүрсний үлдэгдэлд маркшейдерийн хэмжилт хийлгэсэн боловч 39.19 тн-ийн зөрүүг бүртгэлд тусгаагүй,	Хэмжилтийн үр дүнг тухай бүр нягтлан бодох бүртгэлд тусгаж байх	1	1,312.9						1	1,312.9			

Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй														
5			Зардал бууруулах 2.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн	Залруулав	1	2,000.0	1	2,000.0									
6			Орлогын 68.9 сая гүйлгээг бууруулсан бичилт хийсэн	Залруулав	1	68,944.1	1	68,944.1									
7			НБББББичигт орлого, зардал, бараа материалын дансуудтай холбоотой байгууллагын онцлогт тохируулсан заалтыг тусгаагүй байна.	НБББББичигт нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж ажиллах	1	-									1		-
8			Ажиллагсдад ажил хавсран гүйцэтгүүлсэний болон илүү цагийн мөнгийг буруу тооцож илүү олгосон	Цалин хөлсний тооцоололтод тавих дотоод хяналтыг сайжруулах	1	422.8			1	422.8							
9			Ажиллагсдад олговол зохих цалинг буруу тооцож дутуу олгосон	Цалин хөлсний тооцоололтод тавих дотоод хяналтыг сайжруулах	1	351.3									1		351.3
дүн						9	95,686.7	2	70,944.1	1	422.8	2	19,169.4			4	5,150.4
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1			Спортын арга хэмжээ зохион байгуулсан	“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах	1	1,854.0					1	1,854.0					
дүн					1	1,854.0					1	1,854.0					
НИЙТ дүн					23	97,540.7	15	70,944.1	1	422.8	3	21,023.4			4	5,150.4	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 419/А.0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/88/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нүүрсний үлдэгдэлд маркшейдерийн хэмжилт хийлгэхэд 1,312,865 төгрөгийн 39.2 тн нүүрсний зөрүүтэй байгааг бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрүүтэй байгаа нүүрсний үлдэгдлийг бүртгэлд тусгаж, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын Дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Ц.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.Н* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР *М.С* Ц.ХОСЖАРГАЛ
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН *Ж.О* Ж.ОЮУНЦЭЦЭГ
ЗАХИРАЛ

9006109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 420/АОНУ0055
АХГ-2022/88/НХ-СТХ-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Таваас дээш жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй 8 байгууллага, иргэнтэй холбоотой 17,856,461.00 (арван долоон сая найман зуун тавин зургаан мянга дөрвөн зуун жаран нэг) төгрөгийн авлагыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээг авч, үлдэгдлийг тооцсон байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Найдваргүй болох эрсдэлтэй, удаан жилийн авлагыг шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын Дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Ц.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\10.10.10.20\Bichlg_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-121.Docx

0010801732



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 88/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/88/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдад ажил хавсран гүйцэтгүүлсний болон илүү цагийн мөнгийг буруу тооцож, 422,790.00 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй"...; 20.1.7 "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална"...; 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон цалингийн зөрүү 422,790.00 (дөрвөн зуун хорин хоёр мянга долоон зуун ер) төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутган суутган тооцож, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Налайхын Дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Ц.Бямбасүрэн нарт хариуцуулав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ

ЖОЮУНЦЭЦЭГ

4006109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 418/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/88/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Налайхын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уралдаан, тэмцээний зардалд 1,854,600.00 (нэг сая найман зуун тавин дөрвөн мянга зургаан зуу) төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайхын дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Ц.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

9006109
9019120396

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баса тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-119.Docx

0010831028

